

2025/ 9 / 15№ 25/19

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ*Ажлын хэсэг байгуулах тухай*

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийн дагуу:

ҮНДЭСЛЭХ НЬ:

1. Компанийн бүтцэд хэд хэдэн охин компани багтаж байгаа бөгөөд, эдгээрийн алдагдалтай болон ашиггүй үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүүгийн үнэн зөв дүн шинжилгээнд тулгуурлан шийдвэр гаргах зайлшгүй шаардлагатай болохыг **ТЭМДЭГЛЭН;**
2. ТУЗ-өөс үйл ажиллагааны үр ашиг, бүтээмжийг өргөжүүлэх боломж болон зардлын бүтцийг хамруулан бүх холбогдох үйл ажиллагааг нарийвчлан шинжилж, гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах арга хэмжээг тодорхойлох зорилгоор Ажлын хэсэг байгуулах шаардлагатай гэж үзсэн болохыг **ТЭМДЭГЛЭН;**
3. Ажлын хэсгийн дүн шинжилгээний бүрэн хэмжээний тайланг боловсруулан, 2025 оны 10 дугаар сарын 23-нд болох ТУЗ-ийн хурлаар авч хэлэлцэх тухай **ТЭМДЭГЛЭЖ,**

ТОГТООХ НЬ:

1. Компанийн санхүүгийн байгууллагууд болон стратегийн шинэчлэл шаардлагатай үйл ажиллагааны хуулийн этгээдэд гүйцэтгэл, бүтээмж, санхүүгийн үр дүнг үнэлж, сайжруулах зорилгоор энэхүү Ажлын хэсгийг **БАЙГУУЛСУГАЙ.**
2. Ажлын хэсэг нь үйл ажиллагааны үр ашиг, ашигт ажиллагааны гол хүчин зүйлс, өргөжүүлэх боломж болон зардлын бүтцийг шинжилж, хэрэгжүүлэх боломжтой зөвлөмж бүхий дэлгэрэнгүй тайланг боловсруулан 2025 оны 10

дугаар сарын 23-нд болох дараагийн ТУЗ-ийн хуралд танилцуулахаар үүрэг **БОЛГОСУГАЙ.**

3. Ажлын хэсгийн гишүүдийг дараах байдлаар **БАТЛАСУГАЙ.**

- М. Мөнх-Эрдэнэ – Аудит эрхэлсэн захирал
- Б. Золбоо – Гүйцэтгэх захирал
- Г. Уянга - Үйл ажиллагаа хариуцсан Захирал
- М. Энхзул – Хуулийн зөвлөх
- Г. Билгүүн – Санхүү эрхэлсэн захирал
- Б. Шагж – Ардын Тэтгэврийн Данс ХХК-ийн Санхүү эрхэлсэн

Захирал

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд холбогдуулан бүх шаардлагатай арга хэмжээг авах, дэлгэрэнгүй төлөвлөгөөг батлах, Гүйцэтгэх захирлын тушаал гаргах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах болон хэрэгжилтийг цаг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Б.Золбоод үүрэг **БОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч. ГАНХУЯГ

2025/9/15

№ 25/20

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Актив ХЗХ-той байгуулсан 2023 оны 8-р сарын 30-ны өдрийн №121300004606 тоот Зээлийн гэрээний дагуу №120000010585 тоот Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаалах хөрөнгийн нэр, тоо ширхэг, нэгж үнэд өөрчлөлт оруулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ**.
2. Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний нөхцөлийг дараах байдлаар өөрчлөлт оруулахаар **ТОГТООСУГАЙ**

	Барьцаалах хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Барьцаалах хувь	Барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүн
1	ADB Хувьцаа	38,807,000.00	100.29	3,891,954,030	40%	1,556,781,612
2	AIC хувьцаа	2,335,000.00	689.45	1,609,865,750	40%	643,946,300
	Нийт			5,501,819,780		2,200,727,912

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулан компанийг төлөөлж холбогдох баримт бичиг, Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын захирал М.Мөнх-Эрдэнэд тус тус **ОЛГОСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025/ 9/15

№ 25/21

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь Ард Кредит ББСБ ХК болон Ариг банк хооронд 2025 оны 2 сарын 27-ны өдөр байгуулсан №MN950021002199000785 тоот зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах хүрээнд батлан даагчаар оролцохыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Батлан даалтын гэрээний нөхцөл, эрх, үүрэг, хариуцлагыг энэ тогтоолын Хавсралт 1-д заасан нөхцөлөөр **БАТАЛСУГАЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Ариг банктай батлагааны гэрээ байгуулах, үүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025/9/15

№ 25/22

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн №23/32 дугаартай ТУЗ-ийн тогтоолын хүрээнд Ард Секьюритиз ҮЦК ХХК-аас ГрейпСити Монгол ХХК-ийн 11.6 хувийн хувьцааг Компанид шилжүүлснээс үүссэн 1,392,000,000 төгрөгийн өглөгийг Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа болон BS9 токеноор барагдуулахыг **ЗӨВШӨӨРСҮГЭЙ.**
2. Компани өөрийн эзэмшлийн “Ард Кредит” ББСБ ХК-ийн нийт 9,133,334 ширхэг энгийн хувьцааг нэгж хувьцааг 90 төгрөгөөр, нийт 380,000 ширхэг BS9 токеныг нэг бүрийг нь 1,500 төгрөгөөр тус тус үнэлэн тооцож, компаниас Ард Секьюритиз ҮЦК ХХК-д **ШИЛЖҮҮЛСҮГЭЙ.**
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Дотоод аудитын захирал М.Мөнх-Эрдэнэд, холбогдох гэрээ, баримт бичигт компанийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод тус тус **ОЛГОСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ